



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 5/76

Хэрлэн сум

Г.Тэмүүжинг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 56 дугаар зүйлийн 56.1, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, Засгийн газрын 2022 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг” тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Архивын сан хөмрөгийн эрхлэгчийн албан тушаалд Ганболдын Тэмүүжинг түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Г.Тэмүүжиний ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Мөнгөнцэцэг	Архивын тасгийн дарга
Гишүүд:	М.Шаравгаваа	Хууль эрх зүйн хэлтэсийн Мэргэжилтэн
	Д.Энхтуяа	Архив бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3.Г.Тэмүүжингийн цалинг ТҮ-6 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 766,540 (долоон зуун жаран зургаан мянга таван зуун дөч) төгрөгөөр, тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

4.Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Тэмүүжинд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНТУЛГА

